



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 09 дүгээр сарын 15 өдөр

Дугаар 47

Хэрлэн сум

ХХХХVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 46 дугаар хурал 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 93,6 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр хурлын шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын гарсан зарим захирамжинд өөрчлөлт оруулах талаар хэлэлцэх,

*АЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга Б.Баяржаргал*

2. БОЭТ-д тусгаарлагдсан Монгол Улсын иргэдийг тусгаарлалтаас гаргасан талаар танилцуулга хийх,

*Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа*

3. "Петрочайна Дачин Тамсаг" компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээт XIX, XXI талбайд гэрийн ажиглалтад байгаа БНХАУ-ын иргэдийг гэрийн ажиглалтаас гаргах тухай хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа*

4. "Петрочайна Дачин Тамсаг" компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээт XIX, XXI талбайн туслан гүйцэтгэгч тээврийн "Мост-Ази" ХХК-ийн 7 тээврийн хэрэгсэл, "Жи Лин Ху Яан" ХХК-ийн 8 тээврийн хэрэгсэл, "СNPC" ХХК-ийн 10 тээврийн хэрэгсэл Баянхошуу боомтоор нэвтрүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэх,

*Автотээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,

Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

1.1.2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын ээлжит бус хурал, Улсын Онцгой комиссын 29 дүгээр хурлын шийдвэртэй уялдуулан /COVID-19/-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой гаргасан



аймгийн Засаг даргын захирамжуудыг цуцлах захирамжийн төслийг боловсруулж танилцуулахыг,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.1. Монгол Улсын болон БНХАУ-ын гэрийн тусгаарлалт, ажиглалтанд байгаа нийт 60 иргэнийг 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Улсын Онцгой комиссын 29 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлж гэрийн тусгаарлалт, ажиглалтыг цуцлахыг,

Гурав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

3.1."Петрочайна Дачин Тамсаг" компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээт XIX, XXI талбайн туслан гүйцэтгэгч тээврийн "Жи Лин Ху Яан" ХХК-ийн 8 тээврийн хэрэгсэл, "СНРС" ХХК-ийн 10 тээврийн хэрэгслийг "Баянхошуу-Өвдөг" хилийн боомтоор нэвтрүүлэхийг,

Дөрөв. Аймгийн Засаг даргын Тамгын газар,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар,  
Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар,  
Цагдаагийн газар, Гаалийн газар,  
Гадаадын иргэний харьяатын Зүүн бүсийн дэх газар,  
Хил хамгаалах байгууллага,  
Автотээврийн төвийн дарга нарт:

4.1.Монгол, БНХАУ-ын хилийн боомтуудад хэрэгжүүлэх "Ногоон гарц" журмыг судалж танилцахыг,

Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.2.Засгийн газрын хурлын шийдвэр гарсны дараа Улсын Онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр хурлын шийдвэрийн 5.2 дахь заалтын бэлтгэлийг хангаж аймгийн Онцгой комиссын 48 дугаар хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгож байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН



ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ПРОГРАММ,  
ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР,  
АХМАД ЭРАНЖИГҮҮР